



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/218

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны гуравдугаар хуралдааны 04 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсролын чанарыг сайжруулах, багш, сурагчдын сурах идэвх, оролцоо, хүсэл сонирхлыг өрнүүлэх, урамшуулах зорилгоор Улсын олимпиадад амжилттай оролцсон сурагч, багш нарт олгох 7,600,000 (долоон сая зураан зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний “Бүх шатны боловсролын байгууллагын чанар хүртээмжийг сайжруулна.” зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Түмэнжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ



ОЧ
А/218

Аймгийн Засаг даргын 2025 оны
дүгээр сарын 22-ний өдрийн
дугаар захирамжийн хавсралт

ХЭНТИЙ АЙМГИЙН 2025 ОНД УЛСЫН ОЛИМПИАДАД
АМЖИЛТ ҮЗҮҮЛСЭН БАГШ СУРАГЧДЫГ ШАГНАХ ТӨСӨВ

Судлагдахуун	Улын олимпиадад үзүүлсэн амжилт	Сургууль	Овог Нэр	Багш/сурагч	Төсөв
Нийгмийн ухаан	2-р байр мөнгөн медаль	Тэмүүжин сургууль	П.Эрдэнэцэцэг	Багш	1500000
Нийгмийн ухаан	2-р байр мөнгөн медаль	Тэмүүжин сургууль	Х.Хулан	12а Сурагч	1000000
			П.Эрдэнэцэцэг	Бэлтгэсэн багш	1000000
Биологи	3-р байр хүрэл медаль	Бор-Өндөр сургууль	Б.Ууганцэцэг	Багш	1000000
Орос хэл	3-р байр хүрэл медаль	Бор-Өндөр сургууль	Г.Тэнүүн	12а Сурагч	800000
			Д.Нарантунгалаг, Б.Ууганбаяр	Бэлтгэсэн багш	800000
Мэдээлэл зүй	2-р байр мөнгөн медаль	Хэрлэн -1 р сургууль	Д.Батсүх	Багш	1500000
Нийт					7600000